

МАЛЫН УДАМ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол улсад үржүүлж буй баталгаажсан болон нутагшсан үүлдэр, омгийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр илрүүлэн баталгаажуулж үржилд ашиглах замаар нийт сүргийн ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Үзлэг, ангилалтын дүнгээр цөм сүргийн ангийн шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийн удам гарвалыг бүртгэх, үржлийн болон үр төлийн чанараар үнэлэх, аж ахуйн ашигт шинж чанараа үр төлдөө удамшуулан дамжуулах чадварыг тогтоож (цаашид “удам зүйн үнэлгээ” гэх) мэдээллийн сан бүрдүүлэхэд энэхүү журмыг баримтлана.

Хоёр. Удам зүйн үнэлгээ хийх үйл ажиллагаа

2.1. Цөм сүргийн ангийн шаардлага хангасан үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчид удам зүйн үнэлгээг “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасан байгууллага, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, мөн хуулийн 11.2-д заасан үйлчилгээний нэгж нь технологийн арга зүй, аргачлал, зааврын дагуу хийнэ.

2.2. Удам зүйн үнэлгээг мэргэжлийн ангилагч, шинжээч мал зүйч тухайн малын төрөл, ашиг шимийн чиглэлээс хамаарч шаардагдах ашиг шимийн хэмжилт, үнэлгээг хавар болон намрын технологит хугацаанд хийж малыг ялган тэмдэглэж үржлийн дэвтэрт бичилт хийн гэрчилгээ олгоно.

2.3. Үржлийн дэвтэрт малын төрлөөс хамаарч дараах галбир, бие цогцосын хэмжилт болон ашиг шимийн үзүүлэлтүүдийг оруулна. Үүнд:

№	Галбир, бие цогцосын үнэлгээ
1	Цээжний бүслүүр /см/
2	Сэрвээний өндөр /см/
3	Биеийн ташуу урт /см/
4	Шилбэний бүслүүр /см/

№	Ашиг шимийн чиглэл	Ашиг шимийн үнэлгээ
1	Мах	Амьдын жин /кг/
		Хоногийн нэмэгдэл жин /кг/
		Тэжээлийн төлц
		Нядлагын жин /кг/
		Гулуузны жин /кг/
		Нядлагын гарц /кг/
		Өөхний зузаан
2	Сүү	Загас махны зузаан
		Сүүний гарц /
		Уураг /%/
3	Ноос	Тослог /%/
		Ноосны гарц /кг/
		Ноолуурын эзлэх хувь /%/
		Ноолуурын урт /см/
		Ноосны чанар
4	Ноолуур	Ноосны атираа
		Сор үсний урт /см/
		Ноолуурын гарц /гр/
		Ноолуурын голч /мкм/

	Ноолуурын голчийн стандарт хазайлт /мкм/
	Ноолуурын голчийн хувьсал /%/
	Ноолуурын урт /см/

2.4. Үржлийн дэвтэрт бичигдсэн мэдээллийг Малын удам зүйн үнэлгээний нэгдсэн бүртгэлийн программд шивж оруулснаар холбогдох биеийн заалтыг хувиар илэрхийлнэ. Үүнд:

№	Биеийн заалт
1	Чацархагийн заалт
2	Сунацын заалт
3	Биеийн өргөний
4	Цээжний заалт
5	Лагс чамбайн заалт
6	Ясархагийн заалт

2.5. Галбир, бие цогцос, ашиг шимийн үнэлгээ хийгдэж Малын удам зүйн үнэлгээний нэгдсэн бүртгэлийн программд мэдээлэл нь орсноор тухайн хээлтэгч, хээлтүүлэгчийн хувийн мэдээллийн сан үүсч цаашид гарал, үүсэл болон үр төлийн чанараар үнэлэх боломж бүрдэнэ.

Гурав. Хээлтүүлэгчийг үр төлийн чанараар үнэлэх

3.1. Үржлийн хээлтүүлэгчийг үр төлийн чанараар үнэлэхэд тухайн хээлтүүлэгчийн 10-аас доошгүй төлийг шилэн сонгож ялган тэмдэглэгээ хийнэ.

3.2. Шилэн сонгосон төлд ашиг шимийн чиглэлээс хамаарч шаардагдах ашиг шимийн хэмжилт, үнэлгээг хавар болон намрын технологит хугацаанд хийж үржлийн дэвтэрт нэмэлт бичилт хийнэ.

3.3. Ашиг шимийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан сонгон авсан 10-аас доошгүй төлөөс 80% хүртэл шилэн сонголт явуулж аж ахуйн ашигтай шинж чанар хамгийн сайн илэрсэн төлөөр /20%/ өсвөр хээлтүүлэгч нөхөн тавина.

3.4. Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж нь гарал үүсэл тодорхой, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгчийг үржлийн ажлын бүдүүвчийн дагуу малчны суурьт гэрээ, түрээсээр ашиглуулна.

3.5. Үржил селекцийн ажлын хүрсэн түвшний хянан магадлагаанд үндэслэн үржлийн малыг үүлдэр, омгоор баталгаажуулахаас өмнө удам зүйн үнэлгээний нэгдсэн бүртгэлд хамруулж, удамшлын өвөрмөц шинж тэмдэг, шинж чанарыг баталгаажуулсан байна.

Дөрөв.Удам зүйн үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

4.1 Удам зүйн үнэлгээний бүртгэлийг Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Малын удам зүйн үнэлгээний бүртгэл хариуцсан бүтцийн нэгж нь үндсэн чиг үүргийн хүрээнд ерөнхий удирдлагаар хангаж зохион байгуулна.

4.2 Аймаг нийслэлийн Мал үржлийн алба болон Малын удмын сангийн үндэсний төв нь тухайн орон нутгийн болон цөм сүргийн малд үзлэг ангилалт хийх болон үржлийн малын шилжилт хөдөлгөөнийг бүртгэх зэрэгт хяналт тавьж ажиллана.

4.3 Сум дүүргийн Хөдөө аж ахуйн тасаг нь малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж (цаашид нэгж гэх)-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж үзлэг ангилалтад хамрагдаж ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн малын параметрийн үзүүлэлтийг удам зүйн үнэлгээний программд бүртгэнэ.

4.4 Шинээр үүлдэр, омгийн мал баталгаажсан тохиолдолд асуудал хариуцсан нэгж зохих малын код, ашиг шимийн стандарт үзүүлэлтийг програмд оруулна.

Тав. Бүртгэлийн өгөгдлийг хадгалах, дамжуулах

5.1. Малын удам зүйн үнэлгээний программд хамрагдах малын өгөгдлийг дараах байдлаар дамжуулна.

5.1.1. Үржлийн малд технологит хугацааны дагуу үзлэг ангилалт хийж цөм сүргийн малын ашиг шимийн үзүүлэлт болон удам гарвацийн мэдээллийг тодорхой хөтөлж бүртгэнэ.

5.1.2. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар гэрээ байгуулан технологит хугацааны дагуу үзлэг ангилалт хийсэн нэгжийн мэргэжилтэн нь тухайн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг /цаашид тасаг гэх/-ийн мэргэжилтэнд анхдагч материалын хуулбар(шаардлагатай тохиолдолд эх хувь)–ийг хүрүүлнэ.

5.1.3. Тасгийн мэргэжилтэн тухайн сум, дүүргийн программын эрхээр нэвтрэн орж анхдагч материалыг программд оруулах ба стандартын шаардлага хангаагүйн улмаас программд бүртгэгдээгүй малыг тусгайлан бүртгэл хөтөлж хагас болон бүтэн жилээр тайлагнана.

5.1.4. Тус журмын 5.1.2-т заасан тайланг хавар намрын технологит хугацаа дууссанаас 30 хоногийн дотор аймаг, нийслэлийн Мал үржлийн албанд үржлийн ажлын тайлангийн хамт хүргүүлнэ.

5.1.5. Аймаг нийслэлийн мал үржлийн алба нь сум, дүүргийн ирүүлсэн мэдээ тайланг нэгтгэн хагас бүтэн жилийн үржлийн ажлын тайлангийн хамт Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь бүтцийн нэгжид хүргүүлнэ.